

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН АХМАД НАСТАНД ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 дүгээр сарын 26 өдөр

Улаанбаатар хот

1.	Захиалагч байгууллага	Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
2.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
3.	Байршил	Чингэлтэй дүүрэгт
4.	Үйлчилгээ үзүүлэх хугацаа	2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртлэх
5.	Үйлчилгээний цар хүрээ	Чингэлтэй дүүргийн нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд Ахмад настны тухай хуулийн дагуу зөвлөгөө өгөх үйлчилгээ, явуулын үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах үйлчилгээ журам, аргачлал, гэрээнд үүргийн дагуу, чанартай сайн гүйцэтгэх.
6.	Ажлын зохин байгуулалт	<ol style="list-style-type: none">Захиалагч үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргаж гүйцэтгэгчид өгсний дараа үйлчилгээг эхлүүлнэГүйцэтгэгч үйлчилгээг үзүүлэхдээ зорилтот бүлгийн иргэний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг санал болгож ажиллана.Гүйцэтгэгч байгууллага нь Зөвлөгөө өгөх үйлчилгээ, явуулын үйлчилгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 06 дүгээр сарын 21-ны өдрийн A/128 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг, Өдрийн үйлчилгээ, хүчирхийллээс хамгаалах үйлчилгээг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 01 сарын 10-ны өдрийн A/12 тоот тушаалаар баталсан аргачлалаар, үйлчилгээг үзүүлэх хугацаанд чанд мөрдөж ажиллана.Үйлчилгээг гүйцэтгэхэд шаардсан боловсон хүчин нь ажил эхэлснээс дуусах хүртэлх хугацаанд өөр бусад байгууллагад ажиллахгүй.Үйлчилгээ үзүүлэх байгууллага нь байгууллагын товч танилцуулга, үйлчилгээний талаарх мэдээлэл, харилцах утас, хаяг байршлын талаарх мэдээллийг самбарт байршуулж ажиллана.Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхдээ шаардагдах эд хогшил, бараа материал, багаж, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг бүрэн хангасан байна.Гүйцэтгэгч байгууллага нь иргэдэд үйлчилгээг үзүүлэхдээ хэт их ачаалал үүсгэхгүйгээр батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, сар бүрээр тайланг гаргаж, захиалагчид хүргүүлнэ.

7.	Бусад	Гэрээт хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилтийг дүгнэж акт үйлдэнэ.
----	-------	--